

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гомбодарийн Цэрэндорж	Дугаар	L091
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Дадал
Төрсөн газар	Дадал сум	Төрсөн он	1931
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Гилбэрийн хийд, Агацын хийд, Хярхан харуулын хийд	Сүм хийдийн дугаар	ХЭДЛ 095, ХЭДЛ 096, ХЭДЛ 097
Одоогийн сүм хийд	Ганданчойнпэлин хийд	Сүм хийдийн дугаар	ХЭДЛ 098
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 12	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Дадал сумын Гилбэрийн хийд

Богд хаант Монгол улс байгуулагдаж харуулуудыг татан буулгаж харуулын айлууд уугуул нутаг уруугаа нүүцгээж Цэцэн вангийн хошууны айлууд Гилбэрийн харуулын хийдийн нэг дуганыг зөөж явсан ба үлдсэн нэг сүмийг буулгахаар хошуунаас ирсэн хүмүүс дээврийг эвдэн задалж байтал нэгнийх нь ам хамраас цус олгойдож ухаан алдан хэдэн хүн муужирч унаж сандралдан хийдийн шүтээн хилэгнэв үү хэмээн айцгааж үлдсэн цөөн айлууд, оросоос нүүж ирсэн цөөн хамниган айлын хүмүүс адуу үхэр өгч дуганыг худалдан авч 1918 онд сэргээж мөргөлийн газрыг байгуулсан байна.

Хийдийг сэргээн босгоход Рэнчин да лам ихээхэн зүтгэл гаргаж цагийн хурлыг тогтмол болгосон гэдэг.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цэцэн вангийн хошуунд нүүж очсон “Бүдүүн” хэмээх Навааны 7 настай хүү муужирч унах өвчтэй болж хошууны бариач оточ маарамба лам нар эмчилж чадахгүй арга барагдаж Манзушир хутагтад очиж аврал эрэхийг зурхайч авралдан явуулсанд хүү Лувсандоржийг Манзушир хутагтад мөргүүлэн аврал эрсэнд хэн та нарыг нүү гэж албадсан юм. Хоноггүй Гилбэрийн хийд бараадан нүүж оч. Хийдийн сахиул болох ёстой хэмээн аврал буулгасанд зуны аагим халуунд 8 хоног тэмээн тэрэгтэй нутагтаа эргэж ирсэн гэдэг. Тэгээд хүүдээ сахил авахуулж хийдэд суулгасны дараа жил Манзушир хутагтын зарлигаар Гилбэрийн хийдийг өргөжүүлж сүм дуган бариулах лам нар халх, цахар, хятад нийлсэн хорь гаруй хүн тэмээ, үхэр, хайнаг хөсөгтэй ирж хуучин сүмийн хойхно шав тавьж дуган барьж 1920-1922 онд Цогчэн, Чойр, Дүйнхор, Манба дацангуудыг гоёмсог сайхан барьж дуусгасан ба хуучин жижиг дуганыг Зод, Дара эхийн сүм болгон үйл ажиллагаа явуулж байв. Манзушир хутагт тусгай лам томилон Лувсандорж хүүг гол шүтээн Гомбомахагала бурханы чойжин болгох сургууль хийлгэх ажлыг 45 хоног хийлгэж, найман настай хүүд өмсгөх чойжингийн өмсгөл хэрэглэлийг шинээр хийлгэж сахиус оршоох номын багш хоёр ламыг бэлтгэсэн гэдэг.

Чойжин бүүх ажлыг удирдуулахаар Балданбэрээвэн хийдийн чойжин, Богдын хүрээний чойжин гурван хүн ирж /лам/ дүвлэсэн аж. Хийдийн лам хуврагуудыг анги болгон ном хурлын дэг журмыг сургахад багшлах лам нарыг Бэрээвэн, Ламын хүрээ, Гандан, хилийн араас Ага, Цүүгэл, Цэрц зэрэг хүрээ хийдээс номын эрдэм бүхий лам нарыг урин залж ирүүлж 45 хоног сургууль хийсэн байна. Ганданчойнпэллин дацанг гол болгож Гомбомахагала бурхныг хуучин хэвээр сахиус болгон байрлуулж “Юм” ын 16 ботийг шүтээн болгон жил болгон хурж байх болж, хийдийн жасыг байнга ажилладаг болгожээ. Лам зайсан, лам Найдан нар ширээт болж Чойжингийн багшаар Балдан лам / Далай вангийн Санжаа үмзад / Гилбэр харуулын / Гэсгүйд Давга гэвш, Хожим нэмж Жамъяан давга, Маниа, Жамба /Магдаан/ нар томилогдож 4 гэсгүйтэй болж өргөжсөн байна. Төв Гандангийн жишиг ая данг тогтоожээ.

108 боть ганжуурыг залж шинээр Ганжуур жасыг нээж, хоёр жас ажиллах болов. Хуврагуудад гэнэн, гэцэл сахил хүртээж хадаг, шидувт хувааж анхны номын сургалт явуулдаг Чойр, Манба, Тарнийн, Зурхайн гэх мэт дамжаа хичээллүүлж байжээ.

Төвд, монгол бичгийг зэрэг заадаг байв. Зурхайн дамжаа төгсөгчид Ламын хүрээний зурхайчаар шүүлгэж лит бичих эрх олдог. Цохонд уулаар цэг болгон жил бүр цагаан сарын өмнө нутгийн литийг зохиож байжээ. Зурхайч болсон хүн цөөхөн байдаг. Мамба дацангийн дамжаа төгссөн хүн байгаагүй. Гэвш, гавжийн дамжаа барьсан хүмүүс нилээд тоонд хүрсэн. 1936 онд гавжийн дамжаа 12 хүн барьсан. Зарим нь өргөл өргөж, ном багатай ч гавж нэр авсан ба гэвш болсон есөн лам эрдэм ном сайтай лам нар байсан гэдэг.

Зодын дуганд зодоч Гэндэн лам багшлан цөөхөн лам, 20 орчим залуу бүсгүй хандмаа болж хоёр жил орчим Зод, Дарь эхийн сүмд хурж байгаад цагийн эрхээр хурал нь зогссон юм.

Дүйнхорын дуганд 10 орчим лам хурдаг эмэгтэй хүн ордоггүй байсан. Тарни ёгын дамжаа төгссөн хүн сонсогдоогүй, цөөн лам зурхайч болсон байх гэдэг.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Чойр, Цогчэн дуганд олон ном хурдаг байсан, Чойрын лам нар орчуулах ном бичиж бүтээх, гар урлалын талаар сүрч алт мөнгө, модны дархны мэдэгдэхүүнд сурсан. Гавж гэвш болж байгаа лам нартай хүрээ хийдүүдээс эрдэмтэй лам нар ирж ном хаялцан маргалцаж хэлэлцдэг гэнэ. Хийдээс холгүй жижиг нуурын хөвөөнд байр засаж 9 хонгор шарга морь унаж ёслол үйлдэж түгээл түгээж буян үйлддэг байсан газар байдаг.

Майдар эргэх: Зуны сүүл сарын битүүн /30/-нд дөрвөн дугуйтай тэргэнд мухлаг дотор ногоон морь, Майдар бурхан байрлуулж, дуганаас өмнө зүг хүмүүс явганаар түрэн явахад лам нар цан дэлдэн, дамар хонх, дун лавай, яйчил дуугарган уншлага уншин явж хийдийн дөрвөн зүгт зогсоход мөргөлчид мөргөл хийж, мухлаг дотор суусан лам хадаг уясан сунтаг буюу судраар мөргөл үйлдүүлж, өргөл хандивыг хүлээн авч хийдийн горломыг бүтэн тойрч наран жаргах үеэр эргэл хийх ёслол завсарлана.

Шинийн нэгний өдөр морь уралдах, бөх барилдаж, сур шагай харваж баяр наадам хийдэг байсан бөгөөд мөргөлчид олноор цугларч мөргөл хийдэг байжээ.

Хайлан хурах: жил бүр гэлэн гэцэл сахилтай хүмүүс Баянголын хөвөөнд байгаа овоо чулууны дэргэд өглөөний нарнаас өмнө хурж нар мандмагц хонх дуугарган явж сүмд орж хуран орой шөнийн цагаар үдэш түмэн зул Хорхног голын хөвөөнд асааж хурж улмаар түмэн гэлэнгийн хуралд төлөөлөгч явуулж оролцуулж байсан байна.

Гилбэрийн хийдэд Маанийн бүтээл, Тавьд Цэгмидийн чого, Аюушийн цэвээн тавих, 10 хангал, Найдан чого гэх мэт сар улирал, жилийн олон хурлууд хурж, мөргөлчид очиж буян үйлдэж байсан.

1937-38 онд лам нарыг баривчилж сүмийн ном судар, бурхан шүтээнийг эвдэж шатааж устган сүм дуган байрыг сумын сургууль, хүн, малын эмнэлэг, улаан гэр болгохоор зөөж олон жилд сүсэгтэн олны бүтээсэн соёлын өв болох зүйлүүд устгагдсан байна. Ганжуурын 108 боть бусад олон ном судруудыг овоолон шатаахад бүрэн шаталгүй хавар намрын салхинд хэдэн жил хийсэж байсан тухай нутгийн хүмүүс ярьдаг. Дөрвөн дуганы багана холбоо, мод, Богдын морины уяа хэмээх ногоон будагтай – чайга хэмээх 7 алд өндөр мод зэргийг дээд газрын тушаалаар түлшинд зөөж олон тооны том жижиг хүрд суваргуудыг нурааж эвдсэн. Гилбэрийн хийд бол Дадал сумын нутагт байсан таван сүм дацангийн хамгийн том нь юм.

Гилбэрийн хийдэд байсан эрдэм номтой лам нараас заримыг нь нэрлэвэл:

Тогоогийн Санжаа унзад /халх/, эм барьдаг, зурхайч, чойрын ном судалсан. Эрдмээр гайхагдсан. Мяндаг тушаал байгаагүй. 66 насандаа цаазлагдаж хэлмэгдсэн.

Ба лам хэмээн алдаршсан Далай вангийн харъяат Балдан. таван ухаанд мэргэжсэн. Мяндаг тушаалгүй, нэг шавьтай лам 1936 онд таалал болсон.

Давга гэсгүй /халх/ манба, зурхай судалсан эм барьдаг. Цогчэн гэсгүй 56 насандаа таалал төгсжээ. Дугар, нямба хийж байсан газарт нь булаг ундардаг уулын оройд нямба хийж жотгорынхоо хаяанд булаг ундруулж “Баянхааны лам” хэмээн алдаршсан лам. Хийдэд цөөн жил шавилан сууж хөдөөх айлын олон хүүхдэд монгол, төвд ном заасан. /Баргажин лам/ 54 насандаа таалал болжээ.

Дагва хувилгааны гэлэн хэмээх алдартай. Олон шавьтай хамниган лам. Төвд, монгол, орос бичиг үзэж бурхны сургаал ёс журмыг үзсэн гэлүгба ёсыг чанд баримталдаг 73 насалсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цанид хэмээх олонд алдаршсан Дагва гэвш хорь буриад лам. Чойрын номд нэвтэрхий гэгдсэн Дамдин, Данзанравжаа гэх мэт гавж шавь Чойдорж, Дамба, Чойваанчиг зэрэг шавь нар нь сумандаа алба хашсан хүмүүс болсон.

Ламжав гэвш хорь буриад. 22 нас хүртлээ хорь буриадын дацанд шавилан гэвш болж эрдэм сурахаар Оросын газар зүйн эрдэмтэн Монгол, Төвд орноор аялахад ажилчнаар явж Төвдийн Лхас, Энэтхэгийн Дэли, Дармасэд, Хайдарвад зэрэг хотууд, бурхны орноор мөргөл үйлдэж шавилан суух болоход цагаан толгойгоос өөр үзсэн зүйлээс хэтрэхгүй тул Английн далайн хөлөг онгоцонд мөргөлчин ажилчин болж Малайз, Сингапураар дамжин олон сар аялсаар Хятадын Шанхай хотод газардаж хуралчин хүмүүсийг дагалдан Бээжингээр дамжин Манжуур хүрч улмаар Орос, хорь буриадад буцаад дацанд түр суугаад Монголд ирж Гилбэрийн хийдэд хэдэн жил шавилан суусан монгол, төвд, орос хэлтэй ядуу ламын данстай байгаад хар болж малчин, манаач зэрэг ажил хийж байгаад 74 насандаа өөд болжээ.

Равжаа гавж нь хорь буриад лам. Гончигжав, Гочиглодой гэдэг хоёр шавьтай. Танжийн Лэгдэлшийрав, Чойдор /хорь буриад/ хойд Түвдийн Гүмбум, Бадгар, Лхас хотод 12 насандаа эрдэм сурахаар явган явж 16 жил суралцаж гэвш болж ирээд хийдэд шавилан сууж байгаад 37 насандаа баривчлагдаж Орост цөлөгдөж хэлмэгдсэн.

Самдан гэвш, Нямбуу гэвш нар хорь буриад. Номгон Дорж зодоч. Нямба хийж хий биетүүдийг харж үзэж салгалдаг болсон. Улааны шашны ном судалсан лам. 1934-35 онд хар болцгоосон.

Дорийн Шарав зодоч, нууц тарнийн ухаан нямба хийж судалсан, шашны хөгжмийн зэмсгийг бүрэн бүтэн мэддэг /хамниган лам/ бурхны зэмсэг буруу дуугаргаж, алддаг гэж дургүйцэн 1933 онд хөдөө гарч 76 насандаа өөд болсон.

Дашийн Балбар /хамниган/ Гилбэрийн хийдэд шавилж чойр, зурхай судалж байгаад эрдэм сурахаар Ламын хүрээ, Бэрээвэн, Хүүхэн хутагтын хүрээ, Гандантэгчинлэн, Амарбаясгалант хүртэл хэдэн жил явж анги гэгдсэн лам нарт хавчигдан эрдмийн төлөө яваад 1938 онд хар болж мал маллаж нэгдэлд малчин, санетар мэт ажил хийж байгаад 1980-аад онд өөд болсон.

Давгын Дамбажунай, Ядамын Норов, Яндагийн Шаравсамбуу, Шар Жанцан /халх унзадууд/ зурхай чойрын ном судалсан. 1937-38 онд баривчлагдан хэлмэгдсэн байна.

Сэндэний Балдорж тарнийн ёс судалж, Пүрэв сум гүйлгэх эрхийд харах зэрэг үвдис үзүүлдэг ядуу лам байсан. Хар болж мал маллаж амьдарч байгаад 1969 онд өөд болсон.

Цэвээн, Гончигсүрэн /хамниган/ судас барьж өвчин оношилж нутгийн цэцэг ургамал ашиглаж эмчилдэг байсан. Ядуу амьдралтай. 1958 онд нас баржээ.

Сүрэн гэлэн /хамниган/ эрдмийн мөр барин 14 наснаас Түвд, Балба, Энэтхэг, Түрэг, Орос, Халимаг зэрэг орноор явж эрдэм сурч Баруун Зууд гэлэн болсон. Уран дархан, тарнийн ухаан судалж 3-р богдод бараалхан явсан газрын сонин ярьж сархад хувааж Богдын ногоон орд байгуулах ажилд заавар өгч “Арын цагаан лаврин” хэмээх нэр олж байсан лам Гилбэрийн хийд, Хэрийн жацанд очиж хуралд суудаг байсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

1930 оны үед таалал болжээ.

Данзанням Сүрэнгийн / хамниган гавж/ монгол, төвд, орос, манж бичиг мэддэг хинди хэл үзэж байсан. Чойр зурхай судалж байсан. 1930- аад онд Гилбэрийн залуу лам нарт монгол бичиг зааж, латин бичиг өргөхөд санаа тавьж зарим лам нарт зааж байсан. Бие даан бичиг сурч болох дууриалыг үзүүлж байжээ. Бэрц, Ага, Цүүгэл, Гилбэрийн хийдэд ном эрдэмд суралцан 1936 онд “Гавжийн дамжаа бүян бодож барьж” ном хаялцахад өөр хүрээ хийдээс ирсэн лам нарт гайхагдаж байсан гэдэг. 1937 онд Хэрийн дуганд хуралд сууж байхад баривчилж эсэргүү хэрэгт холбогдуулан цаазаар хэлмэгдүүлсэн. Ямар ч хэрэг хийгээгүй байхад цааз дуудлаа хэмээн эсэргүүцээр байсан гэдэг. Эрдэм ном сурахад өөрийнхөө оюун ухаанаа дайчилсан хүн.

Гавж нар: Намсрайн Гэндэн, Хаймцог, Лэгцэг, Бадам, Д.Базар, Р.Бадам, Т.Зундуйдам, Ц.Чойнбил, Даржаа болон аграмба Аюур.

Гэвшийн зэрэгт хүрсэн: Б.Бадрах, Д.Гончиг, Ё.Дамбажамц, Ж.Тавдан, Д.Жамц, А.Лувсанжамц /бурхан бүтээдэг зураач/ Н.Дамбий, Ж.Чойнжуур, Ё.Жимбэгомдо, Ц.Лувсан болон Баруун Зууд аранзэгва (аранжамба) болсон Чо.Дамбий нар 1930-аад онд баривчлагдаж хэлмэгдсэн байна.

Таргалин Шарав /хамниган гэвш/ их унзад. Уран дархан чойрын ном судалж, унзад бүдүүн баргил хоолойгоороо олонд гайхагдаж байсан. Гадаа гарч хар болж мал маллан амьдарч байгаад баривчлагдан хэрэг хийгээгүй учраа гаргасаар үнэнийг олохыг учирлаж ярихыг нь тоохгүй цаазалсан гэдэг.

Дамбын Гончиг - буян үйлдэж байна хэмээн залбирч есөн эрдэнийн зүйлээр ном бичсэний төлөө 1938 онд хэлмэгдсэн.

Гилбэрийн хийдийн зодын /дара эхийн/ сүмд Жамъяны Гэндэн багштай цагийн хурал байв. Улааны шашны ном судалсан. 1938 онд баривчлагдаж хэлмэгдсэн юм. Шавь нар нь: Дорийн Шарав гэлэн, З.Галсан, С.Дэнчин, Ц.Лувсаншарав, П.Самбуу, Д.Зундуйдавга, Е.Шатар.

Гэнэн сахил хүртсэн: О.Даваа, М.Ширнин, С.Нанзад, Ю.Сэжид, М.Цэен нарын 20 орчим бүсгүйчүүд байсан ба нам залуучуудын эвлэл байгуулж сахилаа орхин зодын хурал нь зогссон байна.

Гилбэрийн хийдийн ширээт нар 1900-1937

1. Гилбэр харуулын лам зайсан ИШ
2. Гилбэр харуулын лам Найдан
3. Гилбэр харуулын П.Дагва
4. Гилбэр харуулын Санжаа унзад 1927
5. Онон хошуу Гунгаа 1930
6. Онон хошуу Сүрэг гэлэн 1931
7. Дадал сум Жамъян гэвш 1932
8. Баян сум Цанид лам /чойрын номч/ 1933
9. Дадал сум Равжаа гавж 1934

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.  
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

10. Баян сум Санжаал Гэндэн	1936-37
11. Дадал сум хазгар Шарав	1938
Нярав байсан зарим хүмүүс	
1. Гилбэр харуулын Чүлтэм хүнд	1900-20
2. Гилбэр харуулын Да Гомбодорь	1921-22
3. Гилбэр харуул /Дадал/ Жамъян	1923-24
4. Санжид	1925-28
5. ....	1928-35
6. Дадал сумын Жамбын Чүлтэм	1935-193

Гилбэрийн хийдийн цагийн том хуралд оролцож байсан зарим лам нар

1. Бадаагийн Данзан Улзаас	
2. Эрдэнийн Гунгаанямбуу	буриад
3. Гунгаарагчаа	буриад
4. Эрдэнийн Гүтэв гэвш	
5. Мятавын Гэндэнжав	Хэрийн дуган
6. Завын Даваа	Хэрийн дуган
7. Дашцэрэнгийн Данзан	Хэрийн дуган
8. Лувсандорж	Хэрийн дуган халх
9. Ёндоны Дамбажанцан	Хэрийн дуган
10. Ёндоны Жимбэгомбо	Хэрийн дуган
11. Гэндэний Жамбалжамц	Хэрийн дуган
12. Төрөлийн Зундуйдагва гавж	Хэрийн дуган
13. Сономын Гэндэн /Зондог/	
14. Равданы занабазар /эрхийгүй/	буриад
15. Сугрын зундуй	халх
16. Жамбалын Лувсанцэрэн	халх
17. Цэрэний Наваанчойдог	үлз халх
18. Дара эхийн Наваан лам	үлз халх
19. Чойжилийн Наваан	хэрийн дуган халх
20. Лувсаны Равжаа гавж	үлз халх
21. Чойн Самдан	хярхан
22. Цэвээний Чанрав	хэрийн дуган
23. Хадаасан Шагдар лам	

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.  
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

24.Бадамын Чүлтэмпунцаг

халх

Гилбэрийн хийдэд байсан лам нар

/1930-аад он/

Баруун аймгийн хороололд байртай нь:

1. Ба лам алдартай Балдан Далай вангийн халх
2. Пунцагийн Дагва гэсгүй халх
3. Тогоогийн Санжаа унзад эмч зурхайч халх
4. Бизъяагийн Осоржамц гүрэмч /жаал гэлэн/ халх
5. Цэдэний Лагцэг гавж хам
6. Осоо бага унзад халх
7. Саян гэлүн (хөгшин лам) хам
8. Егнин гэвш хам
9. Мээнтэрийн шагж гэвш хам
10. Авидын Хаймцэг гавж хам
11. Сандагийн Балдорж 9 эрдэнээр ном бичдэг хам
12. И.Жамъяндагва чогчин гэсгүй халх
13. Магдаан Жамба гэсгүй халх
14. Гончигийн Жалцан Унзад халх
15. Пэб Данзан бага унзад халх
16. Хасын Дандар унзад халх
17. Тарнич багш алдартай лам, Очирын Самбуу халх
18. Долоон хүзүү хочтой Наваан ядуу лам халх
19. Сэдэд лам бага унзад халх
20. Жигмидцэрэн унзад /чойр/ халх
21. Чойжилийн Цэвээн унзад /чойр/ халх
22. Суригийн Данзанням гавж хам
23. Сүрэн гэлэн /чойр/ хам
24. Жаргалын Дэчинжамц гавж хам
25. Цэрэний Лувсан унзад хам

Зүүн аймгийн хороололд байртай нь:

1. Гомбодсоны Лэгдэн гавж хам
2. “Хувилгааны” хэмээх Дагва гэлэн хам

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.  
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

3. Чойвсүрэнгийн Дамбий	хам
4. “Цанид” алдартай лам	буриад
5. ...	буриад
6. Гунгаа гавж	буриад
7. Равжаа гавж	буриад
8. Жаргалын шийрав их унзад	хам
9. Моломын Чойжням бага умзад	хам
10. Дамбын Гончиг есөн эрдэнээр ном бичдэг	хам
11. Санжаал Гэндэн гавж ширээт	хам
12. Жамъяны Гэндэн зодоч	хам
13. Авраамын Лувсанжамц бурхан бүтээдэг	хам
14. Цэрэндоржийн Лувсаншарав бага унзад	хам
15. Чойжид ядуу лам	буриад
16. Ламжав гэвш	буриад
17. Жаргалын Тавдан гэвш	хам
18. /Сэмээсэг/ Самдан лам	
19. Навааны Лувсандорж /Гомбын чойжил/	халх
20. Данжийн Лэгдүншийрав, Чойдор гэвш нар	буриад
21. Цэдэвийн Нанзад гэвш	баргажин
22. Гомбын Лувсандамба	халх
23. Самданы Лодой /Эваан Доной/ унзад	халх
24. Хазгар хэмээх Шарав	халх
25. Чогоогийн Лувсан-Ёндон	халх
26. Жандалын Шаравсамбуу зурхайч	халх
27. Бадрахын Наваанлуvsан	халх
28. “Зураач” Ойдов бурхан бүтээдэг	халх
29. “Баянхаан лам” Арсланы Дугар	баргажин
30. Данживан ядуу лам	хятад

### Номын багшийн дэргэд байж шавилан суусан лам

1. Пунцагийн БадамжунайЦогчэн унзад	халх
2. ЯдамынНоров Цогчэн унзад	халх
3. Равдан их унзад	халх
4. Гэндэний Лувсанжамц бага унзад	хам
5. Цэвээний Чойдорж унзад	халх



## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

6. Гомбодоржийн жамъян унзад	хам
7. Гончиглодой унзад	буриад
8. Доржийн Жамъян унзад	хам
9. Дамдины Балдансамбуу унзад	хам
10. Лувсандорж	хам

### Гэцэл сахилтай залуусын нэрс

1. Егининий Шатар
2. Доржийн Жамъян
3. Бадамын Дамба
4. Жүгдэрийн Содов
5. Гэндэний Лувсанжамц
6. Гэндэний Лувсандорж
7. Цэрэндоржийн Лувсаншарав
8. Хандын Шаравзундуй
9. Гончиглодой
10. Гончигжав
11. “Өөлгөр” Ойдов
12. Сандмаа Цэдэв

Гэлэн сахил хүртэж хар болсон хүүхдүүд

Юндэний Чойнваанчиг, Доржийн Дамба, Цэвээний Гэндэн, Доржийн Зундуйдагва, Гэндэний Балдандорж, Сүхийн Дорж, /ноорог/ Дамба, Егнийн Мянзаа, Дамдины Шивнин, “долоон хүзүү” Наваан, Егнийн Самдан, Балданы Ёндонжамц, Палгайн Наваан, Намдагийн Түвдэн, Жаалаагийн Бадраа, Жасраны Осор, Пүрэвийн Лосол, Загдын Жигмэддорж, Долгорын Лувсаншарав, Шаравын Чүлтэм, Жамцын Лувсан, Өлзийн Лувсандамбийлдампил, Чойдогийн Ишдорж, Ойдовын Дамбийням, Жамбалын Цэдэндорж, Чойн Дамдинсүрэн, Бүрэний Дамдин.

Сууж байсан олны дунд яриа байдаг. Хамгийн их холбоотой байсан хийд Хэрийн дуган, улзын лам нар байсан бололтой.

Сэрүүн дуганы лам нар ирж байсан байна.

Гавжийн дамжаа барих ёслолын үеэр мөн Лувсандоржийг чойжин болгох, хийдийг өргөжүүлэх үйлст Манзушир хутагтын завлиганз Их хүрээний Зүүн хүрээ-Вангайн аймаг, Балдан бэрээвэн, Ламын хүрээ зэрэг хүрээ хийдүүдээс гавж нар ирж байсан байна. Хилийн араас Бэрц, Цүүгэл, Самандаас эрдэмтэн цөөн тооны лам нар ирж лам хуврагуудын анги зиндаа болгон ном зааж сургаж Гилбэрийн хийдийг нарийн дэг журам тогтоож тогтмол хуралтай болоход тусалж ая данг Төв халхын Гандангийн жишгээр өөрийн өвөрмөц ая дан тогтоосон гэдэг.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хэр харуул мөргөлийн нэг модон дугантай байсан.1918 оны үед Агийн хамнигад нүүж ирж модон дуган барьсан байна. Амгалан төгөлдөр сүм, Сайн Чойжин сүм халх хамниган лам нар тус тусын сүмд хурлаа хурдаг байсан ба зарим үед томхон хурлыг хамтарч хурдаг болсон.

Халх, хамниган , цөөн тооны төвд ламтай байв. Оросын цагаантан хулгайчид дээрэмчид ирж дээрэмдсэнээс болж Онон голын өмнө дэнж дээр зөөж мөргөлчин сүсэгтэнд үйлчилж байв.

Зуны цагт Егүзэр хутагт лам олон шавь нараа дагуулан ирж “Дотоод ном” гэдгийг тавьж нэлээд нэр хүнд олж улмаар шавь нартаа буу зэвсэг агсуулж буга гөрөөс агнуулж амьдаар бариулж аваачиж Эрдэнэцагааны Лхачвандан ууланд тавьж үржүүлж нилээд өссөн гэдэг. Хатгины Дамдин бишрэлтийн шавь нар халх, хамниган 80 гаруй айл нүүж Алтан овоо хавьд нутаглах болж халх айлууд буцаж Улз голын газар Норовлин, Баян-Уул, Цагаан-Овоо сүм, Халх гол, Бүйр нуур орчим нутаглах болсон ба цөөн тооны айл Алтан-Овоо орчимд үлдсэн гэдэг. Хэрийн хоёр дуганыг 1937-38 онд хааж, лам нарыг нь баривчилж хэлмэгдүүлсэн.

Хорхног гол /Хёрхон харуул/ын эсгий гэр мөргөлийн газар 1917 оны үед Оросоос нүүж ирсэн хамниган буриад хүмүүс модон сүм барьж өргөжүүлсэн боловч шатаж Галттайн голын адаг Ногоон дов гэдэг газар модон дуган шинээр барьж Данзанравжаалин хийд байгуулж халх, цөөн тооны хамниган буриад лам нар хурлаа хурдаг болсон. 1937-38 онд лам нарыг баривчилж сүмийг хааж дуганыг зөөж Дадал сумын улаан булан болгон соёл олон түмний ажил явуулдаг болгосон ч 1955 онд шатсан байна.

Дашванжаалин –Сайхан модны дуган, урт хуруут даяанч “Ёндор лам” хэмээн алдаршсан лам санаачилж Төмстэйн голд анх үүсгэж Балж голын баруун гар уулын бэлд ганцаар ургасан модны ойр модон дуган барьж мөргөлийн газар үүсгэж Ловон Бадмажунайн сургаал Улааны сүм зодын хурал, шарын шашны Цогчэн хурдаг цөөн тооны халх хамниган баргажин лам нарын мөргөлийн газар байсан ба 1933 оны үед Ёндор лам баривчлагдаж шоронд хоригдож хэдэн жилийн дараа суллагдаж ирээд хурлаа сэргээсэн боловч удалгүй нас барж 1937 онд хаагдахад нь шавь нар нь бурхан тахил хэрэглэлийг нууж үгүй хийсэн гэдэг.

Сэрүүн дуган-1916 онд лам Балдан санаачилж Амгалантын Сэрүүн булаг /нуур/ дэргэд Ганданшадавлин хийдийг буриад айлууд дуган барьж мөргөлийн газар байгуулж олонхи нь буриад, цөөн тооны халх хамниган лам нартай хурал хурдаг байжээ. 1937-38 оны үед лам нарыг нь баривчилж эсэргүү хэмээн цаазалж, цөөн тооны хүмүүс 10 жил хорих ял сонсож шоронд хоригдож хэлмэгдсэн. Бурхан номын зүйлийг шатааж устгасан. 1995 онд зохиолч С.Эрдэнэ, дипломатч С.Цэвээн , хүний эх эмч Ц.Сэрээтэр нарын хүмүүс санаачлан эцэг өвгөдийн гэгээн дурсгалд зориулж хэлмэгсдийн цагаатгалын мөнгөөр дуган барьж Очирваань шүтээнтэй мөргөлийн газар нээж дараа нь Биндэр сумын нутаг хуучин сууриас хойд зүгт орших уулын энгэрт Авид бурхан залж гол шүтээн болгон нээсэн байна.

Агацын голын зүүн гарт мөргөлийн газар 1920-иод онд Овоотын дуган нэртэй мөргөлийн газар үүссэн боловч 1930-аад оны үед устсан байна.

Шинэ хийд сэргээгдсэн тухайд:

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хүн мөнх биш хэнд ч тохиож болох, өөд болж, өвчин зовлон тохиолдох талийгаач дээдэстээ буян үйлдэх засал уншлага хийлгэх болоход хүндрэл тохиолдож байдаг тул өөрийн сумандаа сүм хийд мөргөлийн газартай болохсон гэсэн хүсэлтийг дэмжиж өгөхийг хүссэн хүмүүс жил илүү хугацаанд хэд дахин амаар ахмадын байгууллагад ирүүлсээр байна. энэ талаар Сүсэгтний холбоог байгуулж дүрмийг боловсруулж лам явсан хүмүүстэй уулзаж олны төлөө үйлчлэх талаар тохиролцож байна. 7-р ангид сурч байсан хүүхдийн хүсэлтийг харгалзан УБ хот явуулж сургаж байна. сүм хийд мөргөлийн газар байгуулах талаар ил тод чөлөөтэй ярилцаж шийдэх нь зүйтэй. Төр шашны харилцааны тухай хууль, Үндсэн хууль, бусад тогтоол шийдвэрийн асуудлыг зааврын дагуу олонхийн саналаар шийдвэрлэх нь чухал болно гэв.